



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/172

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 13 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбооны Бүгд Найрамдах Герман улс руу хүүхэд, эмэгтэйчүүдийн чиглэлээр туршлага судлахад дэмжлэг хүссэн “Эко мам” төрийн бус байгууллагад 1,000,000 (нэг сая), Мөрөн сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд үйлчлэх “Шинэ өглөө” төвийн үйл ажиллагаанд дэмжлэг хүссэн тус төвийн менежер Д.Эрдэнэцэцэгт 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дээрх зардлын 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ